БНМАУ
ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТНИЙ ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРОО



ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТНИЙ III ИХ ХУРАЛ

II БОТЬ

УЛААНБААТАР
1977

Олон Улсын Монголч Эрдэмтний Их Хурлын Байнгын Хороо
Постоянный Комитет Международного Конгресса Монголоведов
Permanent Committee of International Congress of Mongolists

ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТНИЙ III ИХ ХУРАЛ
ТРЕТЬЙ МЕЖДУНАРОДНЫЙ КОНГРЕСС МОНГОЛОВЕДОВ
THIRD INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

II

Улаанбаатар
Улан-Батор
Ulan-Bator

1977

ХЯТАН НАРЫН ХОЁР БИЧГИЙН ТОГТОЛЦООНЫ ТУХАЙ

Д.Кара (БНУАУ)

Хятан хэл болон хятан бичгийн соёлын дурсгал зүйл бол алтай судлалын хамгийн чухал сонирхолтой судалгааны сэдвийн нэг бөгөөд хятан бичгийн үүсэл гарал, түүний тайлбар, уншлага дуудлага нь шинжээч нарын сонирхлыг аль хэзээнээс татсаар байна.

Эл товчхон өгүүлэлдээ би аль түрүүнээс мэдэгдсэн зарим нэгэн бодит зүйлийг цөөхөн хэдэн шинэ мэдээтэй тулгах санаатай боловч үнэнээ хэлэхэд эрт дээр өнгөрсөн ертөнцийн хөргийг сэргээх бидэнд жинхэнэ шинэ юм хэлэх зааа үгүй билээ.

Цагаан хэрмээс зүүн хойш, X зууны үед мандаж хөгжсөн улс. орноо байгуулсан хятан нар хоёр өөр бичгийн тогтолцоо хэрэглэж байсан нь аль хэзээнээс мэдэгдсэн байна. Их Юань улсын түүхч Тогтын эмхтгэсэн Ляо улсын судраас үзвэл 920 онд Шэньцэ буюу Богдын өргөгдсөний тавдугаар оны эхэн сард анх хятаны их бичиг зохиов. Энэ их бичгийг мөн оны есөн сард дуусав. Хааны зарлигаар хэрэгжүүлж нэвтрүүлэв. (Ляо улсын судар, хоёрдугаар бүлэг). Нөгөө хятан бичгийн үүссэн тухай мөн судрын 64-р бүлгээс уншвал хятан хаан тайзууд уйгарын элч нар ирэхэд тэдний хэл мэдэх хүн олдоогүй. Хатан өгүүлрүүн: Де-ла цовоо сэргэлэн юм. Түүнийг мордуулж, тэднийг угтуул. Тэрвээр тэдэнтэй хориод хоног өнгөрүүлж тэдний хэл аялгуу, бичиг үсгийг сурав. Үүнээс хойш хятаны бага бичгийг зохиогоод энэ бичгийн үсэг цөөхөн байсан боловч түүнд бүх юмыг хамааруулав. Ляо улсын сударт уйгар хааны элч нар хятан хаанд хэзээ албан татвар хүргэснийг үзвэл хятаны бага бичиг бол 925 онд үүссэн бололтой. Цовоо сэргэлэн гэсэн Де-ла бол Тайзуу хааны нэг дүү бөгөөд, тэр бол хожим хааны эсрэг нэг босоод, нэг өргоод удаа дараа өршөөл олсон, хятан нарын Алтан овгийн хүн байсан юм.

Их бичгийг зохиосон цаг бол арав гаруй жил элээсэн хятан хаант улсын анхны эрин үеийн У он мөн бөгөөд хятан нарын тэр үеийн шинэ он тоололтой нэгэн адил тусгай бөгөөд өвөрмөц бичиг үсэг зохиосон явдал бол тусгаар тогтносон төрөө байгуулсны илэрхий билэг тэмдэг байсан юм. Нүүдэлчин түмний соёл иргэншлийн түүхэнд анх ч биш, сүүлч ч биш удаа энд бичиг үсэг өөрийн уг жинхэнэ үүрэгтэйгээр биш, улс төрийн үүрэгтэй үүссэн боловч, хятадын эх бичгүүдийн мэдээ болон хятан нарын нилээн бадаг шүлгийг ч хадгалсан бичгийн дурсгалуудаас үзвэл энэ дэд үүргээ гүйцэтгэсний дээр хятан бичигт ч гэсэн хэзээний бичиг үсгийн уг жинхэнэ үүрэг нь зохих байраа эзэлж хятадаас орчуулсан орчуулгын зохиол, өөрийн өвөрмөц утга зохиол, түүх бичлэг бүхий элбэг бичгийн соёл үүсэв. Толь бичиг, хэл бичгийн зохиолтой ч байсан нь эргэлзээгүй. Сурвалж бичгүүдэд ор мөр нь олддог энэ соёлын баялгаас бидэнд түн цөөхөн зүйл үлдсэн нь харамсалтай бөгөөд олдсон дурсгал бичиг ч гэсэн

зөв тайлбараа олоогүй байхад аль дурсгал нь аль бичгээр бичигдсэн асуудлын хариуг ч олоход бэрх. Хятан бичгийг тааж унших туршилтууд одоо дээрээ амжилтгүй байгаа ба хятан хэлний тухай бусад мэдээ, баримт маш ховор байдаг учир хятан хэлийг аль хэлний бүлэгт багтах асуудлыг бас шийдэшгүй гэж үздэг эрдэмтэд ч бий. Хятадын ном зохиолд цөөхөн хэдэн хятан үсэг, өнгөрсөн зууны нэг бичээсний түүвэрт нэг хятан бичээсний бүтэн уг хадгалагдсаар ирсний дээр X1X зууны Бээжингийн түвд модон бар, элдэв олон цагаан толгойн хураангуй болсон Иигэ хэмээх номд, ямар нэгэн хөшөөнөөс авч, буруу хуулсан бололтой, хятан бичигтэй хэсэг уг орсныг ч дурдаж болно. Хятан бичиг үсгийн жинхэнэ дурсгал зүйл бол манж хятадын хязгаарын чандад зөвхөн X1X зууны сүүлээс мэдэгдэж, шинэ олдсон бичээсний тоо нэмэгдсээр туруун зурчид бичигтэй гэсэн зарим дурсгалыг зурчид биш, харин Ляо улсын хятан бичигтэй мөн гэж тодорхойлох бололцоо гарав.

Одоо хүртэл хорь гаруй хятан бичээс олдсоны дотор зарим нь хятад уг хавсаргасан боловч, Их Монголын Юань улсын үеийн монгол-хятад хоёр хэл бичигтэй хөшөөний адил, хятан, хятад хоёр үгс бол нэг нь нөгөөдхийн үгчилсэн орчуулга биш, тус тус хэлний аясаар утгачлан найруулсаны зэрэгцээ үгс байдаг нь хятан, хятад хоёр хэлний тогтолцоо, хэл зүйн ялгаанаас ч илэрхий. Хятан, хятад хоёрын энэ ялгааны тухай хятад сурвалж бичгүүд тодорхой мэдээ бий.

Хятан хэл бол алтайн төрлийн байгууламжтай, дагавар хэлхдэг хэл байсан гэхэд эрдэмтэн олон бараг бүгдээр санал нийцэж байна. Гэхдээ зарим шинжээч нар тус хэлийг монголжуу хэл, заримууд нь манж-хамниганы үгсаа гэж үзэж, бас зарим нэг нь холимог шийдвэр олохыг эрмэлзэж, хятан хэлийг түрэг, монгол, манж, хамниганы нийлбэр гэж таамаглаж, цөөхөн хэд нь энэ тайлбар тохоход амаргүй хэлний төрөл хамаарлыг тодорхойлох гэсэн бусдын саналыг үгүйсгэхээс холдохгүй. Хятан нарын гүрэн улс хэдэн төрөл хэлтэй, хэд хэдэн овог угсааны иргэдтэй байсны дотроос төр тогтоосон хятан түмнээс эхлэн зурчид, бохай, нивх, хятад зэрэг иргэд хэл хэлээрээ өөр байсан нь тодорхой боловч хятан гүрэн өөрийн өвөрмөц бөгөөд үндсэндээ нэгдмэл нэг улсын хэлтэй байсан гэдэг нь эргэлзээгүй санагдана., Францын Пельо, Америкийн Лауфер болон Унгарын Лигети зэргийн эрдэмтэд Ляо гүрний улсын хэлийг монголжуу хэлүүдийн эртний нэг төрөл гэж үздэгээ удаа дараа нийтэлсэн зохиолоо аль туруун толилуулсан юм. Тэдний саналын нэг үндэс болох, хятад түүх, зохиол зэрэгт хадгалагдсаар ирснээр үл барам, найдвартай тайлбараа олсон хэсэг цөөхөн сурвалж үгнээс дурдвал тав, зуу гэсэн утгатай тооны нэр, махчин шувуу, нар. сар гэсэн утгатай бөгөөд зөвхөн монголжуу хэлүүдийн үүднээс тайлбарлагдах үгс болно. Эдгээр үгс бол үгсийн сангийн нилээн чухал зүйл байгаа учир ямар нэгэн монгол биш хятан хэлэнд орсон монголжуу үгс гэхэд итгэмээргүй юм. "Төмөр" гэсэн утгатай нэг өвөрмөц хятан үгний төрөл үгсаа бас академич Лигетийн аль туруун гарсан нэг зохиолд тодорхой тайлбараа олсон юм. Кашу гэж хэлбэртэйгээр дуудлага нь сэргээсэн энэ сонин үг бол одоо зөвхөн Нуун мөрний дагуурууд ын хэлэнд тохиолдож, дагуур түмний хятан нараас үүссэний нэг чухал гэрч болно. Энэ хятан үг самодий, финн-угор хэлүүд, түүний дотор мажар хэлтэй ч холбоотой гэдгийг энд чухас дурдая. Эртний манж буюу зурчид хэлний эртний монгол

хэлнээс авсан нилээн олон үгс мөн хятан хэлний монголжуу хэл байсны гэрч болно. Лигети багшийн нэг зохиолд товчхон дурдсан бөгөөд тодорхой тэмдэглэсэн авиан зүйн шинжүүдийн тусламжаар Юань улсын өмнө, Алтан улс, Ляо улс бүгдээ бүр түүний өмнөх үед зурчид хэлэнд орсон нилээд монголжуу үгсийг тодорхойлж болно. Ингээд хятан хэлний тухай олдох шууд мэдээ одоо маш хомс боловч, түүнийг шууд бишмэдээтэй тулгаж үзвэл, хятан хэлний монголжуу үгсээ нь илэрнэ.

Дээр дурдсан хоёр хятан бичгийн нэгнээс мөн тийм үгтэй баталгаа саяхан олдсон юм. Үүгээ нь тодорхойлж, дээр дууллага нь ч мэдэгдсэн энэ ганц нэг хятан тэмдгийн тухай хожим ярья. Түүний өмнө хүүчин, шинэ олдсон хятан хэлний дурсгал, хятан бичгийг бичээсний товчхон жагсаалтыг толилуулья.

Гүтайшиминшицзи хөшөөний бичээс, X зууны сүүл,
Синцзун хааны гэрэлт хөшөөний бичээс, 1055 он, Баарин нүүгийн Цилин,
Жэнь-и хааны гэрэлт хөшөөний бичээс, 1075 он, мөн тэнд,
Их амарлингуйн 5-р оны хөшөөний бичээс, 1089 он, Сихушань,
1074 онд амиа хорлуулж паазалсан ярүү найрагч Сюань-и хааны гэрэлт хөшөөний бичээс, 1101 он, Цинлин,
Дасцзун хааны гэрэлт хөшөөний бичээс, 1101 он, мөн тэнд,
Исянь нүүгээд олдсон хөшөөний хагархай, 1103 оны дараа, Исянь,
Алтан улсын дээд түшмэл болсон хятан Сяо овогтны хөшөө, 1150 он, Синлун.

Энэ том бүгдээ томоохон хэдэн хөшөөнөөс гадна
хоёр дөрвөлжин тамганы бичээс,
Хэнтийн нэг хадны бичээс,
Тоосгоны нэг бичээс,
Загасан хэлбэртэй тамганы бичээс,
Дугрөг хүрэл толины бичээс,
Найман өнцөгт хоёр хүрэл толины бичээс,
Шаазангийн ёроолын нэг бичээс,
Хүрэл зоосны нэг бичээс болон
Чингис хааны хятан бичгээр цайз зэрэг цөөхөн үгтэй дурсгалууд олдож мэдэгдсэн юм.

Энд тоочсон дурсгалын ихэнх нь тэмдгүүдийг бүлэг бүлгээр нийлүүлэн бичиж, бүлэг бүр өгүүлбэрийн нэг үгтэй таарах шинжтэй. Үүний тухай хоёр хятан бичгийн нэгний тэмдгийн товъёг ба тэмдгийн толийг анх зохиосон Ленинградын эрдэмтэн В.С.Стариков болон урьдын япон, хятад шинжээч нар ба багшийнхаа саналыг ч дурдуушгай. Хаан хатдын гэрэлт хөшөөний томоохон бичээсэнд тохиолдох энэ нэг төрлийн хятан бичгийг "их бичиг" мөн гэж үздэг эрдэмтэн олонхи нь Ляо улсын судраас дээр дурдсан түүх яриаг үндэслэн "бага бичиг" гэдэг нь уйгар үсэг байсан гэж таамагладаг юм.

Заавал ийм үндсэн дээр биш гэхдээ хятадын Ли Вэнь-синь, Янь-Вань-чжан зэрэг эрдэмтэд хятан хаан, хатдын томоохон хөшөөний бичгийг мөн "их бичиг" гэж үздэг. В.С.Стариковын саналаар бол яг эсрэг бөгөөд, томоохон хөшөөний үгс "бага бичгээр" бичээгдэй.

Ляо улсын сударт гардаг "их бичиг", "бага бичиг" хэмээх хоёр нэрний аль нь аль бичгийг таардгийг шийдэхэд хэцүү бөгөөд бидний одоогийн хамгийн чухал даалгавар ч биш юм. Үгчилэн бүлэг бүлгээр хурааж бичсэн

зүйлийг би энд "бүлэглэмэл" бичиг гэж нэрлэвэл, тус бичгийн тэмдгүүд хадаа бие биений дор цуврууллж бичсэн байдалтай ч гардгийг тэмдэглэх хэрэгтэй. Ийм явбал бол хаан, хатдын гэрэлт хөшөөний дээвэр дээрх магнай үсэгт тохиолдож, үүнд гардаг тэмдгүүд дөрвөлживтэр хэлбэртэй. Эл "бүлэглэмэл" бичгийн тогтолцоо бол хольмог чанараараа орчин цагийн японыхтай адил бөгөөд уттын тэмдэг, үеийн тэмдэг нэг дор хэрэгшиж, үүнээс гадна зарим уттын тэмдэг нь авианзүйн үүрэгтэй үеийн тэмдэг мэтээр ч гарч чаддаг юм.

Гаднаасаа саяыхтай адил, хятад бичгитэй төсөөтэй харагдах боловч, "бүлэглэмэл" бичгээс эрс ялгаатай өөр нэг хятан бичиг бол X зууны сүүлийн Гутайшиминшицзи гэдэг хөшөө сихушаньд олдсон. 1089 оны хөшөө түүнчлэн хоёр дөрвөлжин тамганы бичээс ба Хэнтийн хадны бичээс зэрэгт үзэгдэнэ. Гаднах шинжийг нь хэлбэл, тэмдгүүд нь бие биений дор, цуврууллж бичсэн учир "цуврах бичиг" гэж нэрлэмээр. Энэ бичгийн зарим тэмдэг зурчид, хятад тэмдэгтэй хэлбэр, утга хөөрөөроо нийцэх буюу ойролцоо бөгөөд зарим тэмдэг нь нөгөө "бүлэглэмэл" бичгийнхтэй таарч магадгүй. Янь Вань-чжангийн бодлоор бол энэ нь хятан нарын "бага бичиг" мөн гэвч батлан авах, үгүйсгэн гээх нь хэцүү. Хэрвээ бид зурчид бичгийн одоо хүртэл олдож мэдэгдсэн зүйлийг зурчидийн "бага бичиг" гэж нэрлэхэд андахгүй байвал, хятан нарын "цуврах бичиг" бол Янь Вань-чжангийн бодлогын адил, хятаны "бага бичиг" байсан нь одоо батлашгүй ч гэсэн магадгүй юм. Тус "цуврах бичгийг" таах уншихад эл бичгийн тогтолцооноос ихээхэн юм зээлж авсан бололтой зурчид бичиг бидэнд нэг янзын дөхөм, оньсны түлхүүр өгч болох нь одоо ч гэсэн илхэн юм. Хятан хэлийг монголжуу хэл байсан гэдгийг батлах, одоо дээрээ ганцхан бөгөөд чухал гэрч саяхан олдсон гэж дээр хэлснээ гүйцвэл тэр нь "тав" гэсэн тооны нэрийг дангаар тэмдэглэх уттатай байдгаас гадна "туулай" гэсэн утгатай гурван хэсгээр бүрдсэн тэмдгийн эхний хэсэг, өөрөөр хэлбэл, эхний үеийн тэмдэг болно. Аль түрүүн мэдэгдсэн ёсоор, хятан хэлний "тав" гэсэн үг нь тау юм уу, одоогийн дагуур хэлний таав мэтийн дуудлагатай байж, туулай гэсэн үг нь таул буюу таули байснаас үзвэл, хятадын "тав" гэсэн тэмдгийн таталж бичсэн хэлбэрийг өөрчлөж зохиосон энэ хялбархан хятан бичилбэрийг лав тау гэж унших хэрэгтэй.

Энд өгүүлсэн хэдэн зүйлийг дүгнэж

1. Хоёр хятан бичиг хоёулаа хятад бичлэг, бичгээр уламжлалыг үндэс болгож үүссэн боловч, тусгаар тогтносон хятан гурний өөрийн өвөрмөц бичгийн соёлын биеэ даасан тэмдгийн тогтолцоо болж чадсан;
2. Хятаны "бүлэглэмэл бичиг" бол хятан хэлний монголжуу угсаатай байсныг баталж байна;
3. Хятаны "цуврал бичиг" бол зурчидийн бичгийн үндэс мөн бололтой гэж ном эрдэнийн эрдэмтэн олон нөхөд таныг ядраасны өршөөл гуйя.